

АВТО ЗАМЫН АШИГЛАЛТЫН БЭЛЭН БАЙДАЛ, ТӨЛБӨР ХУРААХ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛАХАД ИХ ӨГӨГДӨЛ ХУВААЛЦАХ, ДАМЖУУЛАХ, НЭЭЛТТЭЙ БА ХААЛТТАЙ СҮЛЖЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АРЧЛАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ БАРИМТ БИЧИГ

Нэг. Ерөнхий зүйл	
1.1	Захиалагч нь: “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ Үнэлгээний арга: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйл 3.15 хэсэг
1.2	Худалдан авах ажиллагааны нэр: “Авто замын ашиглалтын бэлэн байдал, төлбөр хураах ажиллагааг цахимжуулахад их өгөгдөл хуваалцах, дамжуулах, нээлттэй ба хаалттай сүлжээний зохион байгуулалт, арчлалт, аюулгүй байдлын үйлчилгээ” худалдан авах баримт бичиг
1.3	Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич: Байхгүй
1.4	Санхүүжилтийн эх үүсвэр нь: ЗТХЯ, “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ
1.5	Нийт төсөвт өртөг: 440 000 000₮
1.6	Гэрээний хугацаа: 1 жил Нэмэлт тайлбар: Энэхүү худалдан авах ажиллагаанд үнийн санал ирүүлэхдээ 1 жилийн ажил, үйлчилгээний үнийг ирүүлэх ба гэрээг дүгнэхэд Захиалагч, гүйцэтгэгч талын аль нэг гэрээг цуцлах санал гаргаагүй, цаашид гэрээг үргэлжүүлэх нь зүйтэй гэж үзсэн бол нэмж 3 жил ажил үйлчилгээ үзүүлнэ.
Хоёр. БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА	
2.1	Баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: info@rtdc.gov.mn
2.2	Үнийн санал ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: Үгүй
Гурав. ҮНИЙН САНАЛ БЭЛТГЭХ	
3.1	Бүх мэдээллийг “Монгол хэл” дээр ирүүлэх ба Гадаад хэл дээрх бүх материалыг орчуулгын хамт ирүүлнэ
3.2	Хувилбарт санал ирүүлэхийг: Зөвшөөрөхгүй
3.3	Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг ирүүлэх шаардлагатай
3.4	Компаний танилцуулга А4 нэг хуудсанд багтаан албан бичгээр товч ирүүлнэ.
3.5	Ажилтнуудын товч танилцуулга, мэргэжлийн үнэмлэх, нийгмийн даатгал төлсөн баримтыг ирүүлэх шаардлагатай.
3.6	Борлуулалтын шалгуур үзүүлэлт - Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын нийлбэр нь санал болгож буй үнийн нийт дүнгээс багагүй байна.
3.7	Санхүүгийн чадавхын талаар ирүүлэх лавлах баримт бичиг: 2021, 2022 оны санхүүгийн тайлан \аудитаар баталгаажсан\ Харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тухай тодорхойлолт Харилцагч банкнаас олгох боломжтой зээлийн тодорхойлолт

3.8	<p>Оролцогчийн техникийн чадавхи болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <p>Сүүлийн 2 жилийн ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын нийлбэр нь санал болгож буй үнийн дүнгийн 60 хувьтай тэнцүү буюу их байна.</p> <p>Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагад</p> <ol style="list-style-type: none"> 1. Мэдээллийн аюулгүй байдлын бараа, ажил үйлчилгээ 2. Харилцаа холбооны дэд бүтцийн угсралт суурилалт 3. Интернетийн үйлчилгээ 4. Програм хангамж <p>Зэргийг тооцно. Дээрхтэй нийцэхгүй бусад мэдээлэл технологийн ажлын гүйцэтгэлийг ижил төстэй ажлын туршлагад тооцохгүй.</p> <p>Ижил төстэй ажлын гэрээний хуулбар, хүлээлцсэн актыг ирүүлнэ. Тогтмол үйлчилгээ үзүүлэгч бол гэрээний хуулбар ирүүлнэ.</p>
3.9	<p>Тусгай зөвшөөрөл ба бусад тусгай шаардлага: Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгодог Интернетийн үйлчилгээ үзүүлэх Б ангиллын тусгай зөвшөөрөл /Орон даяар/</p> <p><u>Ажлын даалгаварт тусгагдсан шалгуурыг бүрэн хангасан байна.</u></p>
3.10	<p>Түншлэл ба туслан гүйцэтгэх ажлын дээд хэмжээ: Гэрээний дүнгийн 50-аас ихгүй байна.</p> <ul style="list-style-type: none"> - Түншлэгчид тавигдах шалгуур нь 100%-тай тэнцүү байна. - Түншлэлийн эрх үүргийг тодорхойлсон гэрээг баталгаажуулан ирүүлэх ба цаашид бүрэн төлөөлөх үндсэн гүйцэтгэгчийн баримт бичигт нэгтгэн ирүүлнэ.
3.11	<p>Хүний нөөцийн шаардлага:</p> <p>Дараах ажиллах хүчний мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбар, чадамжийг нотлох бусад баримтууд болон сүүлийн 1 сарын нийгмийн даатгалын тодорхойлолтыг ирүүлнэ.</p> <p>Төслийн Удирдагч</p> <ul style="list-style-type: none"> • Мэдээллийн технологи, бизнесийн ба санхүүгийн удирдлага, шинжлэх ухаан, математикийн аль нэг чиглэлийн бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй байх; • Удирдах албан тушаал 3-аас багагүй жил ажилласан байх <p>Ерөнхий инженер</p> <ul style="list-style-type: none"> • Мэдээлэл технологи, Мэдээллийн сангийн зохион байгуулалт, холбоо сүлжээний инженер, компьютерийн шинжлэх ухааны аль нэг чиглэлээр бакалавраас доошгүй зэрэгтэй байх; • 5-аас доошгүй жил ажилласан байх; <p>Бүсийн инженерүүд</p> <ul style="list-style-type: none"> • Мэдээллийн технологи, холбоо сүлжээний инженер чиглэлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй байх; • 5-аас доошгүй жил ажилласан байх • Тухайн бүсийн аль нэг аймагт үндсэн оршин суудаг байх \И-Монголиа системээс тодорхойлт ирүүлнэ.

	Баруун бүс	Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Говь-Алтай
	Зүүн бүс	Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь
	Хойд бүс	Хөвсгөл, Архангай, Сэлэнгэ, Булган, Орхон, Дархан-Уул
	Өмнөд бүс	Баян-Хонгор, Өвөрхангай, Дундговь, Өмнөговь, Говь-Сүмбэр
	<p>Харилцааны туслах ажилтан</p> <ul style="list-style-type: none"> Мэргэжлийн үйл ажиллагааг оролцогч бусад талуудтай харилцан зохион байгуулах туслах 2 ажилтан нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байна. 	
3.12	<p>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл: “<u>Шаардлагатай</u>”</p> <p>Хийж гүйцэтгэсэн ажлын нийт мөнгөн дүнг жил жилээр харуулсан жагсаалт ирүүлэх шаардлагатай жилийн тоо: 2021, 2022 онуудад хийж гүйцэтгэсэн ажлын жагсаалтыг ирүүлнэ.</p>	
3.13	<p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт: Шаардахгүй</p>	
3.14	<p>Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: “<u>Шаардана</u>”</p>	
3.15	<p>Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт: Техникийн даалгаварын дагуу.</p>	
Дөрөв. ИЛГЭЭХ, НЭЭХ		
4.1	<p>Шаардлагатай бичиг баримтуудыг холбогдох хаягаар и-мэйлээр ирүүлнэ .</p>	
4.2	<p>Хүлээн авах эцсийн хугацаа нь: <u>2023 оны 12-р сарын 27</u></p>	
Тав. ҮЗЭХ, ҮНЭЛЭХ		
5.1	<p>Шаардлага хангасан оролцогчтой захиалагч үргэлжүүлэн хэлцэл хийж гэрээ байгуулна.</p>	

АЖЛЫН ДААЛГАВАР

1.3ОРИЛГО

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.6.2-т заасан "Тээврийн ухаалаг системд суурилсан авто замын төлбөр хураах, хяналтын механизмыг бүрдүүлэх", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/226 дугаар тушаалаар батлагдсан "Олон улс, улсын чанартай тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журам"-ын 2.2 дах хэсэг. 2023 оны 02 дугаар сарын 06-ны едрийн 01 дугаартай албан даалгаврын 1 дүгээрт Зам, тээврийн салбарын хэмжээнд 2023 оныг "Бүрэн цахимжсан, бүтээмжийг нэмэгдүүлж, хариуцлага үр дүнг тооцох жил" болгон зарласан.

Дээрх эрх зүйн баримтуудад тулгуурлан "Авто замын ашиглалтын бэлэн байдал, төлбөр хураах ажиллагааг цахимжуулахад их өгөгдөл хуваалцах, дамжуулах, нээлттэй ба хаалттай сүлжээний зохион байгуулалт, арчлалт, аюулгүй байдлын үйлчилгээ" үзүүлэх нь энэхүү ажлын зорилго юм.

Зам тээврийн салбарын цахим шилжилтийн хүрээнд олон төсөл хөтөлбөр хэрэгжиж байгаа ч системийн зөв төлөвлөлт, гүйцэтгэл, өргөжүүлэлт, хөгжүүлэлт, олон систем хоорондын интеграци, аюулгүй байдал, системийг нутагшуулах мэргэжил арга зүйн болон техникийн тусламж үйлчилгээ дутагдсаар байна.

Ялангуяа "Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ, Төлбөр авах цэгүүд, хээрийн нөхцлийн ажилд хяналт, замын бэлэн байдлын мэдээллийг дамжуулах, хөдөлгөөний эрчмийн тооллого зэрэг үйл ажиллагаанд ашиглаж байгаа интернет нь тусдаа ISP-тай нэгдмэл зохион байгуулалтгүй, интернет тасарсан үед ашиглах нөөц сүлжээний төлөвлөлт байхгүй, хаалттай горимд шилжүүлэх шийдэлгүй, хамгаалалт, аюулгүй байдлын хувьд сул, ашиглалтын байдалд хяналт тавьдаггүй зэрэг нь өгөгдөл дамжуулах, хуваалцах ажиллагаанд бодит цагийн хугацааны алдагдлаас үүдэлтэй хүндрэл гарах саатал, догогдол гарах, үйл ажиллагаа зогсох зэрэг нөхцлүүд үүсдэг.

Авто замын ашиглалтын бэлэн байдал, төлбөр хураах ажиллагааг цахимжуулахад их өгөгдлийн боловсруулалт, хөгжүүлэлт хийх програм хангамж, дагалдах ажил үйлчилгээ нь дээрх бэрхшээлийг иж бүрнээр шийдвэрлэж гүйцэтгэгч гэрээний хугацаанд систем болон тэдгээрийг дагалдах бусад үйлчилгээг тогтмол үзүүлж цахим шилжилтийг нутагшуулахад оршино.

Үүний хүрээнд гүйцэтгэгч нь гэрээний хугацаанд дараах системийг нийлүүлж холбогдох ажил үйлчилгээг үзүүлнэ.

1. "Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ, шинээр ашиглалтанд орох удирдлагын төвийн байрыг интернетээр хангах,
2. Төлбөр авах цэгүүдийг интернетээр хангах, интернет тасалдсан ба тусгай шаардлагын улмаас хаалттай сүлжээ ашиглах бол тохируулга хийх,
3. Нөөц сүлжээгээр хангах,
4. Авто замын бэлэн байдлыг хангах зорилгоор хийгдэж буй бүх төрлийн хөдөлгөөнт үйл ажиллагаанд зориулж орон зайн бэрхшээлээс үл хамаарах сүлжээгээр хангах,
5. Сүлжээний төхөөрөмжүүд ба интернет хэрэглээний талаар тогтмол тайлан, статистик гаргах, зөвлөмж өгөх,
6. Өгөгдөл дамжуулах процессийг сүлжээний ба вирусын халдлагаас хамгаалах,
7. Сүлжээний төхөөрөмжүүдийн физик аюулгүй байдлыг хянах, элэгдэл, гологдлыг илрүүлж цаг тухайд нь тайлагнах,

2. Их өгөгдөл дамжуулах нээлттэй ба хаалттай сүлжээнд холбогдох цэгүүд

№	Нэр	Байршил	Хэрэглээ	
Тусдаа ISP-тэй цэгүүдийг нэгдсэн сүлжээнд оруулах				
1	“Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ	Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 29-р хороо, Зам тээвэр хөгжлийн төвийн байр	20 Mbs	
2	Улаанбаатар Налайх ТАЦ	Налайх, тэрэлжийн замын уулзвар	10 Mbs	
3	Улаанбаатар Баруун туруун ТАЦ	Баруун туруун	10 Mbs	
4	Улаанбаатар Эмээлт ТАЦ	Эмээлт	10 Mbs	
5	Улаанбаатар Хоолт ТАЦ	Хоолт	10 Mbs	
6	Улаанбаатар Түргэн ТАЦ	Түргэн	10 Mbs	
7	Төв аймаг Хөшигийн хөндий ТАЦ	Хөшигийн хөндий нисэх онгоцны буудал	10 Mbs	
Хээрийн нөхцлийн интернет сүлжээний хөдөлгөөнт төхөөрөмжийн бэлэн байдлын нөөц				
8	Баруун бүс	Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Говь-Алтай	5 Mbs	
9	Хангайн Бүс	Хөвсгөл, Булган, Архангай, Өвөрхангай, Баянхонгор	5 Mbs	
10	Төвийн бүс	Сэлэнгэ, Дархан, Орхон, Төв	5 Mbs	
11	Говийн бүс	Дунд-Говь, Говь-Сүмбэр, Дорноговь, Өмнөговь,	5 Mbs	
Шинээр нээлттэй ба хаалттай сүлжээнд оруулах цэгүүд				
№	Аймаг	Нэр	Байршил	Хэрэглээ
12	Архангай	Ганц мод	47°28'48.7"N 101°25'34"E	10 Mbs
13	Архангай	Тариат	48°08'49.7"N 99°55'36.9"E	10 Mbs
14	Багануур	Хэрлэнгийн Гүүр	47°41'39.2"N 108°27'38.8"E	10 Mbs
15	Баянхонгор	Түйн Гүүр	46°10'54.9"N 100°43'20.3"E	10 Mbs
16	Булган	Гуртын Гүүр	49°22'41.9"N 102°50'47.0"E	10 Mbs
17	Булган	Баяннуур	47°50'24.2"N 104°27'29.9"E	10 Mbs
18	Говь-Алтай	Есөнбулаг	46.393021°, 96.279967°	10 Mbs
19	Дархан	Дархан	49°22'37.6"N 105°54'52.1"E	10 Mbs
20	Дорноговь	Замын-Үүд	43°45'51.5"N 111°50'01.6"E	10 Mbs
21	Дорноговь	Айраг	45°52'21.4"N 109°13'36.7"E	10 Mbs
22	Дорнод	Хэрлэн	48.030695°, 114.413756°	10 Mbs
23	Дундговь	Мандалговь	45°47'50.6"N 106°18'05.8"E	10 Mbs

24	Завхан	Их-уул	48°42'28.1"N 98°48'18.4"E	10 Mbs
25	Завхан	Сонгино	49°00'57.3"N 95°53'15.1"E	10 Mbs
26	Өвөрхангай	Онгийн Гүүр	46°21'39.5"N 102°48'52.3"E	10 Mbs
27	Өвөрхангай	Хархорин	47°09'21.6"N 102°59'36.6"E	10 Mbs
28	Өмнөговь	Цогт Овоо	44.451432°, 105.346722°	10 Mbs
29	Сүхбаатар	Баруун-Урт	46°40'56.9"N 113°14'41.0"E	10 Mbs
30	Сэлэнгэ	Дулаанхан	49°53'52.0"N 106°15'39.0"E	10 Mbs
31	Төв аймаг	Эрдэнэсант	47.350651°, 104.490965°	10 Mbs
32	Увс	Хандгайт	50°03'56.3"N 91°55'49.8"E	10 Mbs
33	Ховд	Алтай	46°07'06.9"N 91°27'18.6"E	10 Mbs
34	Хөвсгөл	Мөрөн	49.625565°, 100.336666°	10 Mbs
35	Хэнтий	Мөрөн	47.388964°, 110.316357°	10 Mbs
36	Эрдэнэт	Хангалын Гүүр	49°04'36.1"N 104°11'39.3"E	10 Mbs
37	Ховд	Мянгад	48.244545."N 91.906681"E	10 Mbs

Шинээр сүлжээнд холбох цэгийн үндсэн холболт ба MIX-тэй холбогдож хаалттай горимоор ажиллах шийдэл, нөөц холболтын шийдлийн топологи зургийг 1 хуудаст багтаан жишиг байдлаар ирүүлнэ.

Шинээр сүлжээнд холбогдох цэгүүдийн үндсэн сүлжээ, нөөц сүлжээ, дотоодын хаалттай сүлжээнд холбогдох эцсийн цэгийн талаар судалгааг 2 хуудаст багтаан хүснэгт хэлбэрээр ирүүлнэ.

Хөдөлгөөнт төхөөрөмжийн танилцуулгыг 1 хуудаст багтаан зургийн хамт ирүүлнэ.

Аюулгүй байдал хамгаалалтанд ашиглах програм хангамж талаар мэдүүлэх маягт

№	Хэрэгцээ	Ашиглах систем ба програм хангамж
1	Сүлжээний халдлагын хамгаалалт	
2	Вирусын хамгаалалт	
3	Физик аюулгүй байдлын хамгаалалт	
4	Сүлжээний төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагаа, бэлэн байдлын хяналт	
5	Нээлттэй ба хаалттай сүлжээ, нөөц сүлжээнд шилжүүлэх	
6	Хэрэглээний хяналт ба, хориотой хандалтыг илрүүлэх, хаах	

Үнийн санал ирүүлэх маягт

Зам тээврийн хөгжлийн төвийн захирал Х.Пүрэвжаргал танаа:

БидХХК нь “Авто замын ашиглалтын бэлэн байдал, төлбөр хураах ажиллагааг цахимжуулахад их өгөгдөл хуваалцах, дамжуулах, нээлттэй ба хаалттай сүлжээний зохион байгуулалт, арчлалт, аюулгүй байдлын үйлчилгээ” худалдан авах ажиллагааны техникийн болон бусад шаардлагыг хүлээн зөвшөөрч тоогоор \үсгээр\ төгрөгөөр гүйцэтгэхээр үнийн санал хүргүүлж байна.

Энэхүү үнэ нь гэрээний хугацаанд тогтмол байна.

Гэрээний үнийн үндэслэлийг 2 хуудаст багтаан хавсаргав.

ЗАХИРАЛ

Хаяг.....

Утас.....

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл ндор дурдсан утгыг агуулна:
 - 1.1.1. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.2. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
 - 1.1.3. “Гүйцэтгэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.4. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;
 - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;
 - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
 - 1.1.7. “Ажил” гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;
 - 1.1.8. “Ажлын талбай” гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;
 - 1.1.9. “Баталгаат хугацаа” гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;
 - 1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;
 - 1.1.11. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Тайлбар	<p>1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:</p> <p>1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.</p> <p>1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.</p> <p>1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.</p> <p>1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.</p> <p>1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.</p>
<p>ХОЁР. ЗАХИАЛАГЧ</p> <p>Захиалагчийн нийтлэг үүрэг</p>	<p>2.1. Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө.</p> <p>2.2. Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө.</p> <p>2.3. Захиалагч нь ажил гүйцэтгүүлэхтэй холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна.</p>
Захиалагчийн төлөөлөгч	<p>2.4. Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно.</p> <p>2.5. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>2.6. Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.</p>
Талбайд зөвшөөрөл	<p>нэвтрэх</p> <p>2.7. Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно.</p> <p>2.8. Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна.</p>

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ

- Гүйцэтгэгчийн нийтлэг үүрэг
- 3.1. Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө.
- 3.2. Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө.
- 3.3. Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна.
- 3.4. Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна.
- 3.5. Гүйцэтгэгч нь нийт ажлын 10 (арав) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.
- 3.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.
- 3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.
- 3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.
- 3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
- Техникийн болон ажлын талбайн өгөгдөл
- 3.11. Захиалагч нь ажлын талбайн байр зүйн, геологийн, гидрогеологийн, цаг уурын болон байгаль орчны нөхцөлийн талаарх, өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.
- Ажлын талбайн харуул хамгаалалт
- 3.12. Гүйцэтгэгч нь зөвшөөрөлгүй этгээдийг ажлын талбайд оруулахгүй байхаар зохион байгуулна.
- 3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбайг хамгаалах, талбайд ажиллагсад болон зорчигчийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор шаардлагатай газруудад гэрэлтүүлэг тавих, хашаа барих, харуул хамгаалалттай холбогдон гарах зардлыг хариуцна.

- Хог, хаягдал ба нөхөн сэргээлт
- 3.14. Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх явцад ажлын талбайд саад болох хог хаягдал болон цаашид ашиглагдахгүй болсон бараа материал, эд зүйл, тоног төхөөрөмж, машин механизмыг өөр газарт шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажлын талбайг цэвэр байлгана.
- 3.15. Гүйцэтгэгч нь ажлын талбайд авчирсан аюултай материалуудыг зохих ёсоор хадгалж, устгана.
- 3.16. ГЕН-ийн 3.14-3.15-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд түүнтэй холбоотой аливаа үр дагаврыг гүйцэтгэгч хариуцна.
- Археологийн болон бусад олдвор
- 3.17. Ажлын талбай дээрээс олдсон археологийн болон бусад олдвор (бүх чулуужсан амьтан, ургамлын үлдэгдэл, зоос, үнэт зүйлс, бусад эртний олдвор, геологийн болон археологийн ач холбогдол бүхий зүйлс гэх мэт бусад) олдсон тохиолдолд захиалагчид мэдэгдэн, зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгнө.
- 3.18. Гүйцэтгэгч олдворыг гэмтэхээс сэргийлж зохих арга хэмжээ авна.
- Аюулгүй байдал
- 3.19. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.
- 3.20. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.
- 3.21. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална.
- 3.22. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- 3.23. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.
- 3.24. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.
- 3.25. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.
- ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН**
- Ажил эхлэх
- 4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.
- 4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.

- 4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.
- 4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.
- Хугацаа сунгах
- 4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:
- 4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;
- 4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;
- 4.5.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;
- 4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.
- 4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.
- 4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.
- 4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.
- Ажлын явцын тайлан
- 4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.
- 4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- | | |
|-------------------|---|
| Гэрээний үнэ | <p>5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>5.2. Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.</p> <p>5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.</p> |
| Урьдчилгаа төлбөр | <p>5.4. Худалдан авах баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.</p> <p>5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.</p> |
| Төлбөрийн нөхцөл | <p>5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө.</p> <p>5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.</p> <p>5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.</p> <p>5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.</p> <p>5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.</p> <p>5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана.</p> |

ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА

- | | | |
|-------------------------------|-------|--|
| Урьдчилгаа төлбөрийн баталгаа | 6.1. | ГЕН-ийн 5.4-д заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ. |
| Гүйцэтгэлийн баталгаа | 6.2. | Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар ТӨХ-д заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ. |
| | 6.3. | Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:
6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;
6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;
6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон. |
| | 6.4. | Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй. |
| | 6.5. | ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна. |
| | 6.6. | Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө. |
| Чанарын баталгаа | 6.7. | Ажлын чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана. |
| | 6.8. | Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно. |
| | 6.9. | ГЕН-ийн 6.9-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно. |
| | 6.10. | Баталгаат хугацаанд ажилд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө. |
| | 6.11. | ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно. |

- 6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.
- Баталгаат хугацаа 6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.
- 6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ

- Бусдад учруулсан хохирлыг арилгах 7.1. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.
- 7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.
- Захиалагчийн эрсдэл хүлээх 7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:
- 7.3.1. ажлын үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;
- 7.3.2. гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;
- 7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас ажил, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;
- 7.3.4. Захиалагчийн зураг төслийн алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.
- 7.4. Ажлын доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.
- Даатгал 7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.
- 7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.
- 7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.

- 7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.
- 7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ

- | | |
|-----------------------------|---|
| Доголдлыг илрүүлэх, арилгах | <ol style="list-style-type: none"> 8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн ажил, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна. 8.2. Захиалагчийн төлөөлөгч ажлын явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө. 8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ. 8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ. 8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана. 8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно. 8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө. 8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана. |
| Далд доголдол | <ol style="list-style-type: none"> 8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна. |
| Зураг төслийн доголдол | <ol style="list-style-type: none"> 8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна. 8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна. |

ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- Захиалагч гэрээг цуцлах 9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын 5 хоног ажлын талбайг орхисон;
 - 9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гараагүй;
 - 9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;
 - 9.1.4. Гүйцэтгэгч нь худалдан авах ажиллагаанд оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгалын гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;
 - 9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
 - 9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 10 (арав)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;
 - 9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.
 - 9.1.8. Гүйцэтгэгч өөрийн үнийн саналын давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.
- 9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.
- Гүйцэтгэгч гэрээг цуцлах 9.3. Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;
 - 9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
 - 9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол.
- Гэрээг цуцлах журам 9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
- 9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд

- хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.
- 9.6. Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.
- 9.7. Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.
- Гэрээг цуцалсны дараах төлбөр 9.8. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.
- 9.9. ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:
- 9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;
- 9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;
- 9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;
- 9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;
- 9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.
- АРАВ. БУСАД ЗААЛТ
- Мэдэгдэл 10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.
- 10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
- 10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
- 10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:

- 10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
- 10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
- 10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
- 10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
- 10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.
- Төлөөлөгч өөрчлөгдөх 10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.
- 10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
- 10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.
- 10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.
- Ажилд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл 10.12. Талууд ажлын чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын ерөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.
- 10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.
- 10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-д заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.
- 10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.

Гэнэтийн давагдашгүй шинжтэй онцгой байдал	буюу хүчний нөхцөл	<p>10.16. Ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.</p> <p>10.17. Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.</p> <p>10.18. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.</p> <p>10.19. Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно.</p>
Оюуны зөрчих	өмчийн эрх	<p>10.20. Ажлыг гүйцэтгэх явцад болон ажил гүйцэтгэсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсэн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.</p>
Алданги		<p>10.21. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө.</p> <p>10.22. Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.</p> <p>10.23. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.</p> <p>10.24. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.</p>
Маргаан шийдвэрлэх		<p>10.25. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.</p> <p>10.26. Маргааныг зөвшилцөж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.</p>

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 4.1.	Ажил эхлэх хугацаа: <i>[он, сар, өдөр]</i>
ГЕН 4.2.	Ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр:
ГЕН 4.9.	Ажлын явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: Эхлэлийн тайлан 14 хоног Явцын тайлан улирал тутамд
ГЕН 5.2.	Үнийн тохируулга: <i>Хийхгүй</i>
ГЕН 5.4.	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: <i>["Тийм", "Үгүй" аль нэгийг сонгох]</i> <i>Хэрвээ урьдчилгаа төлбөр олгох бол:</i> Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: <i>[мөнгөн дүн бич]</i>
ГЕН 5.5.	Урьдчилгаа төлбөр олгох хугацаа: <i>[ажлын хоног бичих]</i>
ГЕН 5.6.	Төлбөр төлөх хугацаа ба санхүүжилтийн хувь: сар ба улиралаар тэгш хуваан олгоно.
ГЕН 6.1.	Урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх хугацаа: <i>[он, сар, өдөр]</i>
ГЕН 6.8.	Чанарын баталгаа: Чанарын баталгаа шаардах эсэх: <i>Шаардахгүй</i>
ГЕН 6.14.	Баталгаат хугацаа:]
ГЕН 7.5.	Даатгал: <i>[Ажлын онцлогийг харгалзан гарч болох эрсдэлийг тодорхойлон Гүйцэтгэгчийн даатгуулах даатгалуудыг нэрлэн бичих]</i>
ГЕН 10.21.	Захиалагчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: <i>[хоног тутамд 0.5 хүртэл хувиар тогтоож бичих]</i>
ГЕН 10.22.	Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: <i>[хоног тутамд 0.5 хүртэл хувиар тогтоож бичих]</i>